



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/354

Хэрлэн сум

Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ойг тэмдэглэх, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 487 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/78 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Халхын голын байлдааны ялалтын түүхт 85 жилийн арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 10-аас 2024 оны 08 дугаар сарын 14-ны хооронд зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Ойн арга хэмжээний хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах 29,989,440 (хорин есөн сая есөн зуун наян есөн мянга дөрвөн зуун дөчин) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

4. Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



ХАЛХЫН ГОЛЫН БАЙЛДААНЫ ЯЛАЛТЫН
85 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХӨТӨЛБӨР

8 дугаар сарын 10-ны өдөр, “Бямба” гариг

12.00 Монгол-Оросын залуучуудын тойрон аяллын бүрэлдэхүүнийг хүлээн авах

(Чингис хотын хаалганаас тосож авах)

12.40 Монгол-Оросын залуучуудын тойрон ялалын бүрэлдэхүүн, ЗХЖШ, Хэнтий аймгийн удирдлагуудын хамт ЗХУ-ын баатар М.С.Аношин, А.И.Киселев нарын дурсгалын хөшөө, нэр нь үл мэдэгдэх Зөвлөлтийн дайчдын хөшөөнд хүндэтгэл үзүүлж цэцэг өргөх.

13.30 Монгол-Оросын залуучуудын тойрон аяллын бүрэлдэхүүн өдрийн хоолонд орох (Хэнтий аймаг дахь Политехник коллежийн хоолны заал)-д

14.30 Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ойд зориулсан баярын хурал, хүндэтгэлийн концерт (Хан Хэнтий чуулгын концертын их танхим)-д

16.00 Тойрон аяллын бүрэлдэхүүн музей үзэх

18.00 Монгол-Оросын залуучуудын тойрон аяллын бүрэлдэхүүн оройн хоолонд орох (Хэнтий аймаг дахь Политехник коллежийн хоолны заал)-д

19.30 Өндөрхаан хотын залуучууд, хөдөлмөрчид, Орос, Монголын залуучуудын төлөөлөгчдийн хамтарсан үдшийн цэнгүүн

21.30 Ойн арга хэмжээнд зориулсан ёслолын буудлага.

22.00 Монгол-Оросын залуучуудын тойрон аяллын бүрэлдэхүүн амрах (Хэнтий аймаг дахь Политехник коллежийн сурагчийн дотуур байр)-д

8 дугаар сарын 11-ны өдөр, “Ням” гариг

08.00 Монгол-Оросын залуучуудын тойрон аяллын бүрэлдэхүүн өглөөний цайнд орох (Хэнтий аймаг дахь Политехник коллежийн хоолны заал)-д

09.00 Тойрон аяллын бүрэлдэхүүнийг Дорнод аймаг, Чойбалсан хот руу үдэж гаргах. (Чингис хотын Хэрлэн голын гүүрний урд)



Аймгийн Засаг даргын 2024 оны
26 дугаар сарын 26-ны өдрийн
А/354 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХАЛХЫН ГОЛЫН БАЙЛДААНЫ ЯЛАЛТЫН 85 ЖИЛИЙН
ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр	Төлөвлөсөн	Хянасан	Тайлбар
1	Хоолны зардал	9.000.000		
2	Байрны зардал	2.900.000		
3	Материал хэрэгсэл, үйл ажиллагааны зардал	18.089.440		
Нийт		29,989.440		

Нэг. Хоолны зардал

д/д	Сар, өдөр	Хооллох хүний тоо	Хоол		Хэдэн удаа хооллох	Нийт үнэ	Тайлбар
			1 удаагийн 1 хүний хооллох зардал	3 өдөр хооллох			
1	8/10	120	15000	3.600.000	2 удаа	3.600.000	
2	8/11	120	15000	3.600.000	2 удаа	3.600.000	
3	8/14	120	15000	1.800.000	1 удаа	1.800.000	
Нийт						9.000.000	

Хоёр. Байрны зардал

д/д	Сар, өдөр	Байрлах хүний тоо	Хоног	Өрөөний үнэ	Тайлбар
1. Удирдлагын бүрэлдэхүүн					
1	8/10	20	1 хоног 10 өрөө /120.000/	1.200.000	
Нийт				1.200.000	
2. Тойрон аялалын бүрэлдэхүүн					
1	8/10	100	1 хоног 1 хүн 17000 төгрөгөөр бодох	1.700.000	
Нийт				1.700.000	
Бүгд				2.900.000	

Гурав. Материал хэрэгслийн зардал

д/д	Материалын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Чингис хааны хөрөг зураг БХЯ, ЗХЖШ, ОХУ-д	3	180.000	540.000	
2	Тойрон аялалын бүрэлдэхүүнд гарын бэлэг	120	15.000	1.800.000	
3	Урилга хэвлүүлэх	140	1500	210.000	
4	Халх гол-85 хулдаасан хэвлэл	9*3 хэмжээтэй 1	20000	540.000	1.080.000
		5*3 хэмжээтэй 1	20000	300.000	
		3*4 хэмжээтэй 1	20000	240.000	
5	Талархал	5	30.000	150.000	
6	Хөшөөнд өргөх цэцэг, суурийн хамт бэлтгэх	3	200.000	600.000	
7	Цэцэгний тууз	2	20.000	40.000	
8	Нутгийн бренд ОХУ-аас ирсэн зочдод	10	25.000	250.000	

9	Шоу арга хэмжээний үед ёслолын буудлага зохион байгуулах салют	3	440.000	1.320.000	
10	Хөшөө, дурсгалд засвар, үйлчилгээ хийх	Танктай хөшөө 1939 оны дайнд оролсон ахмад дайчдын нэрсийг чулуун дээр бичүүлж мөнхжүүлэх Нэр нь тодроогүй баатруудын хөшөө	3.000.000 2.500.000 2.500.000	2.500.000 2.500.000 2.500.000	7.500.000
11	Хэнтий аймгаас Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ойн арга хэмжээнд оролцох бүрэлдэхүүний шатахуун	Ланд-200 дотор үйлчилгээнд 200км/20 Ланд-200 1400км/20 Ланд-200 1400км/20 Пургон 1400км/18 Зил130 300км/40 Зочдыг хүлээж авах арга хэмжээнд оролцох морьдыг ачих ирэх, буцах	100.800 705.600 705.600 635.040 302.400	100800 705.600 705.600 635.040 302.400	2.449.440
12	ОХУ, Монголоос ирж буй тойрон аялалын бүрэлдэхүүнийг хүлээж авхад	Ааруул, сүү, хадаг, тавгийн идээ	150.000	150.000	
13	Монгол-ОХУ-аас арга хэмжээнд оролцож буй удирдах бүрэлдэхүүнд Засаг дарга хүндэтгэл үзүүлж оройн хоолонд оруулах	20	25.000	500.000	
14	Оройн шоуны арга хэмжээнд Хан Хэнтий чуулга	1	1.500.000	1.500.000	
Бүгд				18.089.440	